

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.2011 оны 6 дугаар сарын 16-ны өдөр баталсан Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийтийн мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7.1.12 дахь заалт нэмсүгэй:

“7.1.12.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн алба.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийтийн мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалт:

“4.1.13.”цахим баримт бичиг” гэж Нийтийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасныг;”.

2/38 дугаар зүйлийн 38.2, 38.3 дахь хэсэг:

“38.2.Цахим баримт бичиг нь стандартаар тогтоосон баримт бичгийн бүрдэл, цахим гарын үсэг, эсхүл давтагдашгүй дугаараар баталгаажна.

38.3.Цахим баримт бичгийн хувь нь цаасан хувьтай адил хүчинтэй байх бөгөөд зөрсөн тохиолдолд анхдагч хувийг баримтална.”

2 дугаар зүйл.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийн “мөрдөнө” гэснийг “мөрдөж болно” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Нийтийн мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3 дахь заалтын “хувьцаа эзэмшигчийн нэр,” гэсний дараа “эцсийн өмчлөгчийн нэр,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.11, 12.12 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/12 дугаар зүйлийн 12.11, 12.12 дахь хэсэг:

“12.11.Улсын бүртгэлийн байгууллага лавлагаа, мэдээллийг Нийтийн мэдээллийн тухай хуулийн 25.5-д зааснаар баталгаажуулан цахим хэлбэрээр олгож болох бөгөөд энэ хуулийн 12.10-т заасантай нэгэн адил хүчинтэй байна.

12.12.Төрийн болон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх харилцааг Нийтийн мэдээллийн хуулийн 17.9, 26.10-т заасны дагуу зохицуулна.”

3 дугаар зүйл. Энэ хуулийг Нийтийн мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Иргэний хуулийн 44 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 44.5 дахь хэсэг нэмсүгэй:

“44.5.Шүүх цахим баримт бичгийг үнэлэхдээ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасныг баримтална.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийтийн мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 38.7 дахь хэсэг нэмсүгэй:

“38.7.Шүүх цахим баримт бичгийг үнэлэхдээ Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасныг баримтална.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийтийн мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 15 дугаар бүлэгт доор дурсан агуулгатай зүйл нэмсүгэй:

“15.33 дугаар зүйл.Нийтийн мэдээллийн тухай хууль зөрчих

1.Хязгаарлалттай мэдээллийг хууль бусаар ашигласан, задруулсан нь гэмт хэргийн шинжгүй бол хүнийг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээд, хууль, эсхүл гэрээний үндсэн дээр төрийн байгууллагын тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа этгээд, олон нийтийн радио, телевиз нь хуульд нээлттэй байлгахаар заасан мэдээллийг нээлттэй байршуулаагүй бол хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийтийн мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.6 дахь заалтын “53 дахь” гэсний дараа “хэсэг, 5.33 дугаар зүйл” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийтийн мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.14.б заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийтийн мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

БАНКИН ДАХЬ МӨНГӨН ХАДГАЛАМЖИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.8 дахь хэсгийн “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд” гэснийг “Нийтийн мэдээллийн тухай хуульд” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийтийн мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалтын “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 14.4.1-д” гэснийг “Нийтийн мэдээллийн тухай хуулийн 8.6.8-д” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийтийн мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.3 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.1.2 дахь заалтын “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн” гэснийг “Нийтийн мэдээллийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийтийн мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

КОНЦЕССЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Концессын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1, 2.6 дахь хэсгийн “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн” гэснийг “Нийтийн мэдээллийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийтийн мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн аудитын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийн “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн” гэснийг “Нийтийн мэдээллийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийтийн мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийн “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн” гэснийг “Нийтийн мэдээллийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нийтийн мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ний өдөр

Улаанбаатар
хот

ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шилэн дансны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 хэсгийн “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн” гэснийг “Нийтийн мэдээллийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нийтийн мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг